



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2017/8



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 287, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 186 байгаагийн 104 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 5 буюу 2.7 хувь өсч, өмнөх сараас 80 буюу 30.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Наймдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 43 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 37 иргэн ажилд зуучлагдсаны 6 буюу 16.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үед байгаагүй болно.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 49, 25-34 насны 75, 35-44 насны 34, 45-54 насны 25, 55 түүнээс дээш насны 3 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 8 сарын байдлаар 241 эх амаржиж, 245 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 75 буюу 23.8 хувиар, төрсөн хүүхдийн тоо 76 буюу 23.7 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 71, бүртгүүлсэн гэр бүл 43, цуцалсан гэр бүл 20 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 9 буюу 81.8 хувиар нас баралт 2 буюу 2.8 хувиар өсч, бүртгүүлсэн гэр бүл 13 буюу 23.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 2 хүүхэд үрчлэгдсэн.



Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 332 хүн шилжин ирж, 304 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 40 хувиар, шилжин явалт 35.5 хувиар тус тус буурчээ.

Зураг 1.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2017 оны эхний 8 сарын байдлаар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлого 5618.8 сая төгрөг, зарлага 6685.9 сая төгрөг болсон байна.

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 112.2 хувьтай, зарлагын гүйцэтгэл 93.6 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2017 оны эхний 8 сарын байдлаар 3627 хүнд 937.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 817 хүн буюу 18.4 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 63.1 сая төгрөг буюу 7.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2017 оны эхний 8 сарын байдлаар 958 хүн хамруулж 484.0 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 531 хүн буюу 35.7 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 53.0 сая төгрөг буюу 9.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2017 оны эхний 8 сарын байдлаар 2669 хүн хамруулж 453.0 сая төгрөг олгосон нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 286 хүн буюу 9.7 хувиар буурч, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 116.1 сая төгрөг буюу 34.4 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2017 оны 8 дугаар сарын мэдээгээр 194 байгууллагын 5332 даатгуулагч иргэн, үүнээс 669 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 376 ажилтны



дундаж цалин 677.9 мянган төгрөг, төсөвт 55 байгууллагын 1674 ажилтны дундаж цалин 637.8 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 649 ажилтны дундаж цалин 1206.2 мянган төгрөг, 108 ХХКомпаний 1790 ажилтны дундаж цалин 710.8 мянган төгрөг, бусад 18 аж ахуйн нэгж байгууллагын 174 ажилтны дундаж цалин 310.9 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2017 оны эхний 8 сарын байдлаар



III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2017 оны эхний 8 сарын байдлаар 270 эх амаржиж, 2016 оны мөн үетэй харьцуулахад 46 буюу 14.6 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхэд 269 үүнээс 145 нь хүү, 124 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 49 буюу 15.5 хувиар буурсан байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 3 бүртгэгдсэн байна. Эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 8 сарын байдлаар





Халдварт өвчин эхний 8 сарын байдлаар 134 буюу 10000 хүн амд 80.0 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 100 тохиолдлоор буурчээ.


Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 70157 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 14944 хүнээр буюу 17.6 хувиар, 3153 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 229 хүнээр буюу 6.8 хувиар буурсан байна.

2017 оны эхний 8 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 4239, халдварт өвчин 134 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 8 сарын байдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2017 оны эхний 8 сарын байдлаар 121 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 буюу 13.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 8 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тодорхой хэмжээгээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 28 байгаа нь өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 51.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 18 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 76 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 8 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2017 оны эхний 8 сарын байдлаар 221,0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 158.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 70.0 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 57.0 сая төгрөг буюу 26,5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны эхний 8 сарын байдлаар давхардсан тоогоор 407 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 224 хүнээр буюу 35,4 хувиар өссөн байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 8 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2017 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3 хувиар, 2016 оны жилийн эцсээс 3.2 хувиар өсч, өмнөх сараас 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 8 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2017.VIII}{2016.VIII}$	$\frac{2017.VIII}{2016.XII}$	$\frac{2017.VIII}{2017.VII}$
	Ерөнхий индекс	103.0	103.2
Хүнсний бараа, ундаа, ус	100.8	104.2	98.4
Согтууруулах ундаа, тамхи	103.2	103.0	99.4
Хувцас, бөс бараа, гутал	103.6	102.2	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	106.0	101.0	101.8
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.3	101.4	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.1	102.1	101.3
Тээвэр	109.0	109.2	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	99.9	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	99.7	99.7	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	102.9	102.9	99.7

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ


**VI. Төсөв санхүү**

2017 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 8854.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 9039.2 сая төгрөг болж 102.0 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 10930.7 сая төгрөг, гүйцэтгэлээр 8789.5 сая төгрөг болж 80.4 хувийн гүйцэтгэлтэй байна.


2017 оны эхний 8 сарын байдлаар авлагын үлдэгдэл 16.4 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 58.8 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй, газар тариалан**


Аймгийн хэмжээнд 2016 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 185558 хээлтэгч малын 141520 буюу 76.3 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 99.0 хувьтай байна. 2017 оны эхний 8 сарын байдлаар 2181 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 5.3 дахин бага байна. Том малын зүй бус хорогдлын 19.6 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1. Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, толгойгоор






Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, толгойгоор



2017 онд аймгийн хэмжээнд нийт 38.7 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 5.7 га талбайгаар буюу 24.9 хувиар, хүнсний ногоо 1.0 га талбайгаар буюу 5.4 хувиар, тэжээлийн ургамал 5.9 га талбайгаар буюу 2.4 дахин буурсан байна.

Ургац хураалтын мэдээгээр аймгийн хэмжээнд 08 дугаар сарын 30-ны байдлаар 8.5 тн төмс, 6.5 тн хүнсний ногоо хураасан байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, 2017 оны байдлаар, га



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2017 оны эхний 8 сарын байдлаар 29.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 тэрбум төгрөг буюу 8.4 хувиар, оны үнээр 30.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.6 тэрбум төгрөг буюу 16.9 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 90.1 хувь буюу 26.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 90.9 хувь буюу 27.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.



Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр



IX. Цаг агаарын мэдээ 8 дугаар сард:

Хур тунадас: Энэ сард нийт 41.1 мм хур тунадас орсон байна.


Салхи: Ихэнх хугацаанд 4 -9 м/сек, зарим үед 11 м/сек хүрч салхилсан.

Агаарын температур: Дунджаар 17.6 хэм дулаан, хамгийн ихдээ 28.2 хэм дулаан байлаа.


2017 оны 9 дугаар сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж 8-13 хэм дулаан байх бөгөөд олон жилийн дунджаас 1.0-1.5 хэмээр дулаан байх төлөвтэй.

Говьсүмбэр аймгийн нутгаар энэ сард орох хур тунадас нь уур амьсгалын дунджаас бага бороо орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүлч, хоёрдугаар ба гуравдугаар арав хоногийн эхээр сэрүүсч шөнөдөө 2-7 градус, өдөртөө 18-23 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтэрч шөнөдөө 0-5 градус өдөртөө 13-18 градус дулаан байна.



1 дүгээр зураг. 2 дугаар сарын агаарын температурын уур амьсгалын дундаж (°C)



3 дугаар зураг. 2 дугаар сард ордог хур тунадасны уур амьсгалын дундаж (мм)



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	318	269	84.5
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	181	186	102.7
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	234	134	57.2
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	140	121	86.4
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	9958.5	9039.1	90.7
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	8781.7	8789.5	100.0
Авлага	сая.төг	16.4	16.4	100.0
Өглөг	сая.төг	468.1	58.8	12.5
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	27206.3	29582.2	108.7
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	25420.3	30023.2	112.7
Төллөсөн хээлтэгч	толгой	150604	141520	93.9
Гарсан төл	толгой	151790	142333	93.7
Хорогдсон төл	толгой	3335	1422	42.6
Бойжсон төл	толгой	148455	140911	94.9
Том малын зүй бусын хорогдол	толгой	11478	2181	19.0



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 8 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	338	287	84.9
Үүнээс: эмэгтэй	231	162	70.1
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	181	186	102.7
Үүнээс: эмэгтэй	123	104	84.5
Ажлын байрны захиалга	0	43	*
Ажилд зуучлагдсан иргэд	0	37	*
Үүнээс: эмэгтэй	0	6	*

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Амаржсан эх	316	241	76.2
Төрсөн хүүхэд	321	245	76.3
Үрчлэгдсэн хүүхэд	3	2	66.7
Бүртгүүлсэн гэр бүл	56	43	76.7
Цуцалсан гэр бүл	11	20	181.8
Нас баралт	69	71	102.8
Шилжин ирсэн	553	332	60.0
Шилжин явсан	471	304	64.5

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Сангийн төрөл	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
ЭМНД-ын сангийн орлого, сая.төг	4 082.1	5618.7	137.6
ЭМНД-ын сангийн зарлага, сая.төг	5 101.2	6685.9	131.0

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VIII		2017 I-VIII		$\frac{2017 \text{ I} - \text{VIII}}{2016 \text{ I} - \text{VIII}}\%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	4 444	873.9	3 627	937.0	81.6	107.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1 489	537.0	958	484.0	64.3	90.1
Халамжийн тэтгэвэр	350	257.2	264	252.0	75.4	97.9
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 139	297.2	694	231.9	60.9	82.9
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	2 955	336.9	2 669	453.0	90.3	134.4
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	603	47.2	728	150.5	120.7	318.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	206	42.4	96	19.4	46.6	45.7
Нийгмийн халамжийн үйлчилгээ	468	27.4	379	27.0	74.5	98.5
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	495	51.0	250	85.9	50.5	168.4
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	7	8.1	5	7.3	71.4	90.1
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 176	160.6	1 211	162.7	102.9	101.8

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Төрсөн эх	316	270	85.4
Амьд төрсөн хүүхэд	318	269	84.5
Эрэгтэй	157	145	92.3
Эмэгтэй	161	124	77.0
Амьгүй төрсөн хүүхэд	2	1	50.0
Нийт нас баралт	51	57	111.7
Эмнэлгийн нас баралт	13	5	38.4
Хоног болоогүй нас баралт	8	5	62.5
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	6	2	33.3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	3	150.0
Эмчлэгдсэн өвчтөн	3382	3153	93.2
Амбулаторийн үзлэг	85101	70157	82.4
Халдварт өвчин	234	134	57.2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 8 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	140	121	86.4
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	68	57	83.8
Өмчлөх эрхийн эсрэг	46	42	91.3
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	5	3	60.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	12	171.4
Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	4	4	100.0
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	5	1	20.0
Бусад гэмт хэрэг	5	1	20.0



Гэмт хэрэгт <u>холбогдог</u> сод	142	119	83.8
15 хүртэлх насны	1	2	200.0
16-34 насны	102	74	72.5
35 ба түүнээс дээш насны	39	43	110.2
Боловсрол – Дээд	21	21	100.0
Боловсрол - Тусгай дунд	17	6	35.2
Боловсрол – Бүрэн дунд	54	35	64.8
Боловсрол – Бүрэн бус дунд	28	31	110.7
Боловсрол – Бага	16	8	50.0
Боловсролгүй	6	18	300.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	6	9	150.0
Ажилгүй иргэд үйлдсэн	64	55	85.9
Эмэгтэй хүн оролцсон	25	17	68.0
Хүүхэд оролцсон	7	13	185.7
Бүлгээр үйлдсэн	18	11	61.1
Согтуугаар үйлдсэн	59	37	62.7
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	129	121	93.7
Гудамж талбайд	38	35	92.1
Гэмт хэргийн улмаас нас барсан	4	8	200.0
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	91	76	83.5
Учирсан хохирол / сая.төг /	291.0	221.0	75.9
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	215.0	158.0	73.4

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 \text{ I – VIII}}{2016 \text{ I – VIII}}\%$
Нийт орлого	9 958.5	9039.1	90.7
Урсгал орлого	3 223.1	3 009.9	93.3
Татварын орлого	3186.2	2 237.5	70.2
Татварын бус орлого	987.2	772.3	78.2
Тусламжийн орлого	6495.2	6029.2	92.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Нийт зарлага	8781.7	8789.5	100.0
Урсгал зардал	7592.3	7846.0	103.3
Хөрөнгийн зардал	1 019.6	943.4	92.5

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Авлага	16.4	16.4	100.0
Өглөг	468.1	58.8	12.5
Төсөвт байгууллагын тоо	45	49	108.8
Төсөвт байгууллагын ажиллагсад	769	783	101.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Төрөл	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Бүгд	150 604	141520	93.9
Ингэ	193	120	62.2
Гүү	3 833	4 302	112.2
Үнээ	3 861	3 980	103.0
Эм хонь	73 019	69 113	94.7
Эм ямаа	69 698	64005	91.8

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Сумд	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Дүн	150 604	141520	93.9
<u>Баянтал</u>	23 933	21 713	90.7
Сүмбэр	111 712	102 643	91.8
<u>Шивээговь</u>	14 959	17 164	114.7



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Төрөл	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Бүгд	148 455	140911	94.9
Ботго	181	116	64.1
Унага	3 782	4 283	113.2
Тугал	3 719	3 948	106.1
Хурга	72 249	68 820	95.2
Ишиг	68 524	63 744	93.0

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Сумд	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Дүн	148 455	102643	69.1
<u>Баянтал</u>	23 786	21 713	91.2
Сүмбэр	109 979	101 896	92.6
<u>Шивээговь</u>	14 690	17 218	117.2

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Төрөл	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Бүгд	11 478	2 181	19.0
Тэмээ	1	3	300.0
Адуу	305	29	9.5
Үхэр	474	105	22.1
Хонь	4 092	805	19.6
Ямаа	6 606	1 239	18.7

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Сумд	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Дүн	11 478	2 181	19.0
<u>Баянтал</u>	1 981	260	13.1
Сүмбэр	6 498	1 838	28.2
<u>Шивээговь</u>	2 999	83	2.8



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Төрөл	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Бүгд	3 612	429	11.7
Тэмээ	0	0	*
Адуу	213	7	3.3
Үхэр	167	27	16.2
Хонь	1 381	208	15.1
Ямаа	1 851	187	10.1

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Сумд	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Дүн	3 612	429	11.7
<u>Баянтал</u>	158	31	19.6
Сүмбэр	695	377	54.2
<u>Шивээговь</u>	2 759	21	0.8

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Нийт	27206.3	29582.2	108.7
Нүүрс олборлолт	26029.7	26640.7	102.3
Боловсруулах үйлдвэр	69.1	1 589.7	23 дахин
Цахилгаан,дулааны эрчим хүч	1107.5	1 351.9	1 22.0

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 I - VIII}{2016 I - VIII} \%$
Нийт	25420.3	30023.2	118.1
Нүүрс олборлолт	24214.0	27293.3	112.7
Дулаан	98.8	1 483.0	15 дахин
Усан хангамж, ус ариутгал	4.3	4.2	97.6
Бусад	1191.9	1242.7	1 04.2



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлт	2016 I-VIII	2017 I-VIII	$\frac{2017 \text{ I} - \text{VIII}}{2016 \text{ I} - \text{VIII}} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	24214	27293.3	112.7
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	26029.7	26640.7	102.3
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	1131	1 179	104.2
Ажиллагсад	595	553	92.9

Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017